



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,
удирдамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.1.1, 2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга Цэрэннадмидын Шинэхүүг томилсугай.

2.“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч Ц.Шинэхүүд даалгасугай.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 04 сарын 23-ны өдрийн
162 дугаар тогтоолын хавсралт



**“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ТӨРИЙН ӨМЧИЙГ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ
ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам” болон энэхүү удирдамжийг баримтална:

1.Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлттэй танилцан үнэлэлт өгч батлан, цаашид Компанийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулахад чиглэсэн байдлаар саналаа өгч оролцох;

2. Ногдол ашиг хуваарилах талаар гарсан шийдвэр нь Компанийн тухай хууль, Улсын Их Хурал, Засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас гарсан тогтоол, шийдвэрүүдтэй нийцэж буй эсэхэд үнэлэлт өгч, Компанийн санхүүгийн болон нийгмийн өгөөжийн үзүүлэлтийг сайжруулах талаарх үүрэг чиглэлийг Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад өгөх;

3.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлантай танилцан, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг чиглэл өгөх;

4.Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”, Засгийн газрын 2024 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”, компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу томилох;

5.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөвтэй танилцан, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, саналаа тусгаж оролцох;

6.Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлал, загварыг Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, аргачлалтай нийцэж буй эсэх, Компанийн санхүү, нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, компанийн засаглалын үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэсэн эсэх зэргийг харгалзан, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлах.